

НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Огноо : 2018.04.06

Тендер шалгаруулалтын нэр: Томоохон баг, суурин газруудыг эрчим хүчээр хангах, сумдын 0.4 кВ-ын шугамын өргөтгөл, шинэчлэлт /улсын хэмжээнд/” төсөл, арга хэмжээний хүрээнд Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Баянхонгор, Өмнөговь аймгуудад хэрэгжих барилга угсралтын ажлууд

Тендер шалгаруулалтын дугаар: ЭХЯ/201803008

Эрчим хүчний яам нь эрх бүхий тендерт оролцогчдоос **“Томоохон баг, суурин газруудыг эрчим хүчээр хангах, сумдын 0.4 кВ-ын шугамын өргөтгөл, шинэчлэлт /улсын хэмжээнд/” төсөл, арга хэмжээний хүрээнд Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Баянхонгор, Өмнөговь аймгуудад хэрэгжих барилга угсралтын ажлууд**”-ыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу. Тендерт оролцохын тулд эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар цахим тендерийн хураамж төлнө. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жил /2015, 2016, 2017/-н аль нэг жилд хийж гүйцэтгэсэн ажлын борлуулалтын орлогын хэмжээ нь тендерт санал болгож буй дүнгийн 50 хувиас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тухайн багцад санал болгож буй үнийн дүнгийн 80 хувиас багагүй байна.

Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 3 жил буюу “2015, 2016, 2017”

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:

Эрчим хүчний яамны “03.2.1: 0.4-10 кВ, 03.2.2: 0.4-15, 03.2.3: 0.4-35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар,

Тендерийн хамт дараах дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Үүнд:

Багц 2: 15,538,000 төгрөг Багц 3: 5,000,000 төгрөг

Багц 8: 16,136,000 төгрөг Багц 9: 10,724,000 төгрөг

Тендерийг 2018 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 15 цаг 00 минутаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2018 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 15 цаг 30 минутад нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

www.tender.gov.mn

17060 Улаанбаатар хот. Хан-Уул дүүрэг.
Чингисийн өргөн чөлөө. Эрчим хүчний яам.
Засгийн газрын XIY байр. 3 давхар. 303 тоот өрөө. Утас: 62263064
www.energy.gov.mn